

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АНХАН, ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ТУСЛАМЖИЙН ХЭЛТСИЙН  
ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Б.ПҮРЭВЖАВЫН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
<b>Зорилт 1. 2 сар хүртэлх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалт, чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр:</b>							
1.	<b>Арга хэмжээ 1.1.</b> Нярайн тархи хөргөх, уушигны гипертензийн оношилгоо, эмчилгээний заавар боловсруулж батлуулах, эмчилгээг нутагшуулна.	Шинээр батлуулах, нэвтрүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	40%	Нярайн тархи хөргөх, гипотермийн эмчилгээний зааврыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын А/470 тушаалаар батлуулсан. Нярайн үргэлжилсэн уушгины даралт ихсэлтийн үед азотын исэл эмчилгээ хийх зааврыг Эрүүл мэндийн сайдын А/54 дүгээр тушаалаар батлуулсан.	1 сард	100 хувь
	Дэд арга хэмжээ-1.1.1: Нярайн тархи хөргөх эмчилгээ, оношилгооны зааврыг боловсруулж батлуулна, хүний нөөцийг сургаж, бэлэн байдлыг хангана.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	20%	Нярайн тархи хөргөх эмчилгээнд оношилгоогоор гадаадад 2 эмч, Улаанбаатар хотод 16 эмч ажлын байран дахь сургалт хийсээн. Нийслэлийн амаржих газрууд, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Гипотермийн эмчилгээнд 12 нярай хамрагдсан.	2 сард	100 хувь

	Дэд арга хэмжээ-1.1.2: Нярайн уушигны гипертензийн эмчилгээ, оношилгооны зааврыг боловсруулж батлуулна, шаардлагатай хүний нөөц, сургалтын бэлэн байдлыг хангана.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь		20%	Нярайн үргэлжилсэн уушгины даралт ихсэлтийн үед азотын исэл эмчилгээ хийх зааврыг Эрүүл мэндийн сайдын А/54 дүгээр тушаалаар батлуулсан. Нярайн уушгины даралт ихсэлтийн үед азотын исэл эмчилгээ хийх сургалтад гадаадад 1, Улаанбаатарт нярайн 16 эмчийг сургасан. 104 нярайд нитрикоксид эмчилгээг 24-72 цагийн хугацаатай хийж амьсгалын аппаратаар удирдсанаар эрчимт эмчилгээний ор хоногийг багасгасан. Өргөө, Амгалан, Хүрээ амаржих газрууд, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II-ийн нярайн тасгууд Нитрикоксид эмчилгээний аппаратаар бүрэн хангагдсан.	2 сард	100 хувь
2	Арга хэмжээ 1.2 Дутуу бага жинтэй, өвчтэй нярайн эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ		50%	“Нярайд амьдрал бэлэглэе” Нярайн эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг сайжруулах сургалт Дархан-Уул аймагт 2025 оны 5 сарын 8-10-ны өдрүүдэд 60 нярайн эмч, Дутуу төрөлтөөс сэргийлэлт, дутуу нярайн менежмент, бага жинтэй нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах олон улсын сургалт, семинарыг 2025 оны 6 сарын 9,10-ны өдрүүдэд 150 эх барих, хүүхэд, нярайн эмч зохион байгуулсан.	1-11 сар	100 хувь
	Дэд арга хэмжээ-1.2.1: Дутуу бага жинтэй нярайн менежментийн туршлага солилцох хурал, уулзалт зохион байгуулах.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь		20%	“Дутуу төрөлт: сэргийлэлт ба дутуу нярайн менежментийн шилдэг туршлага” сэдэвт Дутуу бага жинтэй нярайд Имж эх асаргааны ач холбогдол, имж эх асаргааны аргачлал-дадлага, явцын хяналт хийх, эхэд нь зөвлөгөө өгөх, Имж тээвэрлэлтийн талаар онол дадлага хосолсон олон улсын сургалтыг 6 сарын 9. 10-ны өдрүүдэд зохион байгуулсан. .Сургалтад 21 аймаг, нийслэлийн	2-6 сар	100 хувь

					<p>амаржих газар, хүүхдийн эмнэлгийн эх баригч эмч, нярайн нийт 150 эмч нар оролцсон. Сургалтад Ази Номхон Далайн Перинатологийн Нийгэмлэгүүдийн Холбооны ерөнхийлөгч Профессор Ким Хан Сук, Энэтхэгийн Гандийн их сургуулийн Эх барих эмэгтэйчүүдийн тэнхимийн эрхлэгч, Ази Номхон Далайн Перинатологийн нийгэмлэгүүдийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Профессор Мийлэнд Шаах, Ази Номхон Далайн Имж эх сүлжээний тэргүүн, Профессор Соккорра Мендоза, Филиппин улсын Сан Фернандогийн сургалтын бүсийн эрүүл мэндийн төвийн хүндэт зөвлөх Дайси Гарсия нар ирж туршлагаа хуваалцаж, хичээл заалаа.</p>		
	<p>Дэд арга хэмжээ-1.2.2: Орон нутгийн нярайн эмч, эрчимт эмчилгээний эмч, хүүхдийн эмч нарын мэргэжлийн ур чадвар сайжруулах—гадаад, дотоод сургалтад хамруулна.</p>	<p>Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>		30%	<p>“Нярайд амьдрал бэлэглэе” Нярайн эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг сайжруулах сургалт Дархан-Уул аймагт зохион байгуулж, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, Амгалан-амаржих,-Хүрээ амаржих, Өргөө амаржих газар, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн нярайн эмч нар нийт 60 хүн оролцсон. Нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулах, эмнэлгийн тусламжийг багаар үзүүлэх зарчимд суралцсан. Сургалтыг АНУ-ын MAYO эмнэлгийн профессор Phil Fisher, АНУ-ын Калифорнийн их сургуулийн нярай профессор Carlos G. Ramos, АНУ-ын Хьюстон хотын Хүүхдийн эмнэлгийн эмч</p>	4-12 сар	100 хувь

					Kendra Martinez нар лекц, дадлага зохион байгуулсан.		
3.	<b>Арга хэмжээ 1.3.</b> Нярайн цогц эрт илрүүлгийг үндэсний түвшинд нэвтрүүлж, хэрэгжилтийг хангана.	Нярайн өвчлөлийг эрт илрүүлэх арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	Улсын хэмжээнд нүдний ретинопати 30 % зулайн эхо 0 %, бодисын солилцоо 3 аймагт, сонсголын эрт илрүүлэг 7 эрүүл мэндийн байгууллага д хийгдэж байна.	50%	Нярайн цогц илрүүлгийг үндэсний хэмжээнд зохион байгуулах талаар эмнэлзүйн зааврыг боловсруулсан.  2025 оны эхний хагас жилийн байдлаар нярайн цогц эрт илрүүлгийн түнхний үзлэгт 6093, сонсголын илрүүлэгт 2081, нүдний илрүүлэгт 4501, зүрхний үзлэгт 2164, бодисын солилцооны эмгэгийн илрүүлэгт 2906, зулайн ЭХО-д 1449 нярайд тус тус хамруулсан байна. Нярайн эрт илрүүлэгт нийслэлийн амаржих газрууд ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, аймгуудаас БОЭТ-үүдэд бүрэн хийгдэж байна.	1-12 сар	100 хувь
	Дэд арга хэмжээ-1.3.1: Нүдний ретинопатийн эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	30%	20%	Нүдний ретинопатийн эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулсан. Хугацаа болоогүй.	1-10 сар	100 хувь
	Дэд арга хэмжээ-1.3.2: Хүүхдийн бодисын солилцоо, сонсголын эмгэгийн эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0	20%	Хүүхдийн бодисын солилцоо, сонсголын эмгэгийн эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулсан. Хугацаа болоогүй.	1-10 сар	100 хувь
<b>Зорилт 2. Бага насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалт, бодлого</b>							
5	<b>Арга хэмжээ 2.1</b> “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж	2021 оны 760 дугаар тушаал		“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөгөөг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2025-5-30-ний өдрийн тушаалаар батлуулсан.	1-7 сар	100 хувь

		батлуулсан байна.					
	Дэд арга хэмжээ-2.1.1: Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөний төсөлд үнэлгээ хийгдэж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн байна.	Үнэлгээний тайлан	2021 оны 760 дугаар тушаал		“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөний төсөлд үнэлгээ хийгдэж, ажлын хэсгээр хэлэлцүүлсэн. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт хэрэгжүүлэхээр тусгасан 81 үйл ажиллагааны 35 (43.2 %) үйл ажиллагаа үр дүнтэй бүрэн хэрэгжилттэй, 16 (19.7%) заалт тодорхой үр дүнд хүрсэн байна (70%) гэж үзлээ. Харин 15 (18.5%) үйл ажиллагаа нь эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн 12 (14.9%) үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжсэн байгаа бөгөөд 3 (3.7%) үйл ажиллагаа огт хэрэгжээгүй үнэлэгдсэн.	1-2 сар	100 хувь
	Дэд арга хэмжээ-2.1.2: Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2030 оны Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	2021 оны 760 дугаар тушаал		Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2030 оны Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөгөөг 3 дугаар зорилтод 17 үйл ажиллагаа боловсруулж батлуулсан.	1-7 сар	100 хувь
6	Арга хэмжээ 2.2. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журам шинэчлэн батлуулна.	Батлагдсан тушаалын тоо	2021 оны 263 дугаар тушаал	1	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журмын Эмнэлзүй-эмгэг судлалын конференци зохион байгуулах, Хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүнийн хэсгийг боловсруулсан.	1-12 сар	80 хувь
	Дэд арга хэмжээ-2.2.1: Хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журам боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	40%	Хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журмын төслийг 4 хавсралттайгаар боловсруулж байна.	2-12 сар	80 хувь

8	<b>Арга хэмжээ 2.4.</b> Хоол тэжээлийн цочмог дутагдалтай хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмнэл зүйн заавар боловсруулах	Батлагдсан эмнэл зүйн заавар	-	50%	Хоол тэжээлийн цочмог дутагдалтай хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмнэл зүйн зааврын төслийг боловсруулж байна.	6-11 сар	100 хувь
9	<b>Арга хэмжээ 2.5</b> Томуу, томуу төст өвчин амьсгалын замын өвчний үеийн тусламж, үйлчилгээг зохицуулалтаар хангах	Томуу, томуу төст өвчин амьсгалын замын өвчний үеийн тусламж, үйлчилгээний төлөвлөлт	-	60%	Томуу, томуу төст өвчнөөр хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг ХӨСҮТ-өөс Баянзүрх нэгдсэн эмнэлэг рүү шилжүүлэх тушаалыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/83 дугаар тушаалаар батлуулсан. Амьсгалын замын халдвар, Улаанбурхан, Менингококцемийн халдварын хүнд тохиолдлын үед ажиллах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх эмнэлзүйн багийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/78 дугаар тушаалаар байгуулсан. Хугацаа болоогүй.	2-12 сар	80 хувь
12	<b>Арга хэмжээ 2.8</b> Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн шинэчлэн баталсан загвар, Морбас үнэлгээ, өсөлт, хөгжлийн үнэлгээ хийх сургалтыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагад сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	-	50%	Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн шинэчлэн баталсан загвар, 9,18,36 сартай хүүхдийн илрүүлэг, үзлэгийг Морбас үнэлгээ, өсөлт, хөгжлийн үнэлгээ хийх сургалтын удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. 9,18,36 сартай хүүхдийн илрүүлэг, үзлэгийг сонгогдсон аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад үзүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр Японы Хүүхдийг Ивээх сантай Эрүүл мэндийн сайд 2025 оны 6 сарын 2-д гэрээ байгуулсан.	4-12 сар	100 хувь
	Дэд арга хэмжээ-2.8.1: 9, 18, 36 сартай хүүхдүүдийн хөгжлийн хоцрогдлын эрт илрүүлгийг хийх сургалтын удирдамж батлуулсан байна.	Батлуулсан удирдамж	-	80 хувь	9, 18, 36 сартай хүүхдүүдийн хөгжлийн хоцрогдлын эрт илрүүлгийг хийх сургалтын удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар батлуулсан.	4-6 сар	100 хувь

	Дэд арга хэмжээ-2.8.2: Хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх 9,18,36 сартай хүүхдэд сонгогдсон аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэхээр Японы Хүүхдийг Ивээх сантай хамтран ажиллана.	Байгуулсан санамж бичиг	2023 он	100 хувь	9,18,36 сартай хүүхдийн илрүүлэг, үзлэгийг сонгогдсон аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад үзүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр Японы Хүүхдийг Ивээх сангийн суурин төлөөлөгч Л.Баян-Алтай, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан 2025 оны 6 сарын 2-д харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.	3-6 сар	100 хувь
--	--	-------------------------	---------	----------	---	---------	----------

**Зорилт 3. Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургуулийн насны хүүхдийн эрт илрүүлгийн дараах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр**

1	<b>Арга хэмжээ 3.1</b> Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх сургуулийн эмч, эрүүл мэндийн анхан шатны эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулна.	Сургалтын хөтөлбөр, удирдамж	-	40	Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх сургуулийн эмч, эрүүл мэндийн анхан шатны эмнэлгийн мэргэжилтэн нарт 2025 оны 1 сарын 31-д Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын өсвөр үеийн эмч нарт, 2 сарын 7-д 21 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн хүүхэд, өсвөр үеийн эмч нарт сургалт зохион байгуулсан. 2025 оны 4-15-аас 5 сарын 15-ны хооронд “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” сэдэвт өсвөр-үеийн-эрүүл-мэндийг-дэмжих-сарын-аяны удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан зохион байгуулсан. Хугацаа болоогүй.	1-12 сар	100 хувь
3	<b>Арга хэмжээ 3.2</b> Хүүхдийн хэрх өвчний илрүүлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж, эрт илрүүлгийн мэдээг цахимд бүртгэнэ. Илрүүлгийн дараах А стреттококкийн фарингит, хэрхийн эмчилгээнд хамруулна.	Хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний хувь	-	40 хувь	Хэрхийн шалтгаант Хүүхдийн Зүрхний өвчнөөс сэргийлэх, бууруулах төлөвлөгөөний төслийг 2025-4-07-ны өдрийн Төслийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж 2025 оны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар баталсан. “Хүүхдэд тохиолдох А бүлгийн стрептококкын шалтгаант хоолой, залгиурын үрэвсэлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг судлах” судалгааны арга, аргачлалыг НЭМҮТ боловсруулсан,	4-12 сар	100 хувь

					Анагаах ухааны судалгааны ёс зүйн хороогоор хэлэлцүүлнэ.		
4	Дэд арга хэмжээ - 3.2.1 Хэрхийн шалтгаант Хүүхдийн Зүрхний өвчнөөс сэргийлэх, бууруулах төлөвлөгөөний төслийг Төслийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, батлуулна.	2025 оны Батлагдсан төлөвлөгөө	2024 оны төлөвлөгөө	100 хувь	Хэрхийн шалтгаант Хүүхдийн Зүрхний өвчнөөс сэргийлэх, бууруулах төлөвлөгөөний төслийг 2025-4-07-ны өдрийн Төслийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж 2025 оны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар баталсан.	4-6 сар	100 хувь
	Дэд арга хэмжээ - 3.2.2:Хэрх өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгааны арга аргачлал боловсруулна, судалгааг эхлүүлнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	20 хувь	"Хүүхдэд тохиолдох А бүлгийн стрептококкын шалтгаант хоолой, залгиурын үрэвсэлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг судлах" судалгааны арга, аргачлалыг НЭМҮТ боловсруулсан, Анагаах ухааны судалгааны ёс зүйн хороогоор хэлэлцүүлэхэд бэлэн болсон.	6-12 сар	100 хувь
5	Арга хэмжээ 3.3 Сургуулийн хүүхдийн нүд, шүд, зүрхний эмгэгийн эрт илрүүлгийг орон нутагт хэрэгжүүлнэ, эмчилгээнд хамруулна.	Эрт илрүүлгийн хамрагдалтын тоо	Нийслэд 30800	30000	Нийт 6 настаны үзлэгийн хамрагдалт 80 хувьд хүрсэн. 21 аймагт 38720 6 настан Зүрхний эрт илрүүлэгт хамрагдахаас 36247 хүүхэд хамрагдсан. Сургуульд суурилсан эрт илрүүлэг, үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлэгт эмч нарын баг ажиллуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/164 дүгээр тушаал батлуулсан.	1-12 сар	100 хувь
6	Дэд арга хэмжээ - 3.3.1: 6 настай хүүхдийн зүрхний эрт илрүүлэг, ЗЦБ-ийн дараахь Зүрхний ЭХО оношилгооны үзлэгийн хүний нөөц, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлага, эмнэлгийн бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	60	2025 оны 6 сарын байдлаар 21 аймагт 38720 6 настан Зүрхний эрт илрүүлэгт хамрагдахаас 36247 хүүхэд хамрагдаж, зүрхний эрт илрүүлгийн үзлэг 94 хувьтай байна. Үүнээс 7207 (19.9%) хүүхдэд зүрхний эмгэг илэрч, 3200 гаруй хүүхдийг лавлагаа шатлалын зүрхний эмчид илгээж, эмчилгээ, оношилгоо хийгдэж эхлээд байна. Нийт 6 настаны үзлэг 80 хувьд хүрсэн.	2-12 сар	100 хувь

Нэмэлт үүрэг, даалгавар

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Ургийн болон төрөлхийн хөгжлийн гажгийн талаар уулзалт зохион байгуулж, ҮАБЗ-д танилцуулах	ҮАБЗ-ийг үнэн зөв мэдээлэл, шаардлагатай баримтаар хангана	-	ҮАБЗ мэдээллээр хангагдсан байна.	Монгол Улсын Ургийн болон Төрөлхийн хөгжлийн гажгийн өнөөгийн байдлын талаарх мэдээлэл - Ургийн гажиг, зонхилон тохиолдох хромосомын эмгэгийн бодит байдал, тоо баримт NGS лабораторит хийгдэж байгаа НИПТ шинжилгээний талаар мэдээлэл танилцуулгыг ҮАБЗ-ийн реферэнт Солонго, ЭХЭМҮТ, удамзүйн шинжилгээ хийж байгаа хувийн хэвшлийн лабораторийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг хийж, мэдээллийг ҮАБЗ-д өгсөн.	2-3 сар	100 хувь
2	Улаанбурхан, менингококкт халдварт өвчний хүнд, нэн хүнд тохиолдолд эмнэлзүйн зөвлөгөө өгөх баг байгуулах	Батлуулсан тушаал	-	Тушаал батлуулсан байна.	Улаанбурхан, Менингококцемийн халдварын хүнд тохиолдлын үед ажиллах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх эмнэлзүйн багийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/78 дугаар тушаалаар байгуулсан.	2-3 сар	100 хувь
3	Улаанбурхан өвчний эмнэл зүйн сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.		Сургалтад хамрагдагсдын тоо	Улаанбурхан өвчний эмчилгээ, оношилгооны заавраар ХӨСҮТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-өөс аймаг, дүүргийн НЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 1670 гаруй эмч нарт сургалт зохион байгуулсан	3-5 сар	100 хувь
4	ХӨСҮТ-ийн томуугийн тусламж, үйлчилгээг шилжүүлэх тухай	Батлуулсан тушаал	-	Тушаал батлуулсан байна.	ХӨСҮТ-т хэвтэн эмчлүүлж байсан Томуу, томуу төст өвчний Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/83 дугаар тушаалаар батлуулсан.	3-4сар	100 хувь

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
5	Дэлхийн Эрүүл Мэндийн Өдрийг тэмдэглэх	“Эрүүл эхлэл- Итгэлтэй ирээдүй-2025” ДЭМБ өдрийг зохион байгуулах		Тэмдэглэлт өдрийг зохион байгуулсан байна.	Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх уулзалт, ажлын хэсэг байгуулж, Эрүүл мэндийн сайдаар удирдамж, Төрийн нарийн бичгийн даргаар төсөв батлуулж, ДЭМБ-д хүргүүлсэн. “Эрүүл эхлэл-Итгэлтэй ирээдүй-2025” өдөрлөгт ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын ажилчид, НҮБ-ын Олон улсын байгууллага, Монголд суугаа гадаадын элчин сайд, төлөөлөгч, эх барих, хүүхдийн эмч нарыг оролцуулан зохион байгуулсан.	3-4 сар	100 хувь


**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	1	2	3	4	5	6	7
1.	<b>Арга хэмжээ 1.</b> Төрийн албан хаагчийн ёс зүйн богино хугацааны сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан байна.	0	0	Монгол Улсын Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Ёс зүйн сургагч багшийн 5 өдрийн сургалтад хамрагдаж, Үндэсний хэмжээний сургагч багшийн үнэмлэх авсан.	2-10 сар	100 хувь
	<b>Арга хэмжээ 2.</b> Албан тушаалын онцлогоос хамаарсан шаардлагатай	Сургалтад хамрагдсан байна.	0	1	Их өгөгдлийн статистик тоо мэдээлэл боловсруулах МУИС-ийн сургалтад хамрагдсан.	1-3 сар	100 хувь

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	сургалтад хамрагдана. /дата анализ/						

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын  
 Анхан, лавлагаа шатлалын тусламжийн  
 хэлтсийн Хүүхэд, өсвөр үеийн эмнэлгийн  
 тусламж, үйлчилгээ хариуцсан шинжээч  
 (Албан тушаал)

Б.Пүрэвжав /........../

2025.06.09

(Нэр, гарын үсэг)

(Огноо)